



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Даланзадгад сумын ерөнхий боловсролын 4-р сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОМА-2023/113/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Өмнөговь аймаг

2023 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас:99014247 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Болормаа
Утас:80077408 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК
Утас:99099119 Цахим хаяг:gerelthuhaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



Нутгийн хэлсэлтийн орон 358 тнвт, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46062
Утас: (976) 7063 1539, Цэвэр хуудас: www.audit.mn
Цахим хуудас: audit.gov.mn

00230217 № 43

талай _____-ын № _____-т

ДАЛАНЗАДГАД СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 4 ДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Н.ЗОРИГТ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Даланзадгад сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Даланзадгад сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв тогилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засаг даргын нөөц хөрөнгөөр 6 дугаар ангийн хүүхдүүдийг үдийн хоол хөтөлбөрт хамруулсан.

Аудитын гол асуудал

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтад "Хувьсах зардлын дундаж нормативаар санхүүжүүлэх аргачлал" батлагдаж боловсролын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд санхүүжүүлдэг болсон байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд тогилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

016200050

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДСОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Үзүүлэлт	(сая төгрөгөөр)	
	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	145.7	352.4
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,111.1	3,927.0
Нийт хөрөнгийн дүн	4,256.8	4,279.4
Нийт өр төлбөрийн дүн	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,256.8	4,279.4
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,256.8	4,279.4
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	1,495.3	2,022.4
Үйл ажиллагааны зардлын дүн	1,594.1	1,999.4
Үйл ажиллагааны үр дүн	(98.8)	23.0
Үйл ажиллагааны бус үр дүн	-	0.4
Үйл ажиллагааны нийт үр дүн	(98.8)	22.6
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Засгийн газрын оруулсан капитал	2,970.3	2,970.3
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	312.5	312.5
Хуримтлагдсан үр дүн	1,073.5	996.6
Эцсийн үлдэгдэл	4,356.4	4,279.4
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,356.7	1,980.7
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,352.8	1,759.0
Үйл ажиллагааны ЦМГ	3.9	221.7
Хөрөнгө оруулалтын ЦМГ	3.1	21.1
Санхүүгийн үйл ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.8	200.6
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	200.6
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,980.7	1,780.1

Урсгал зардал	1,980.7	1,750.8
Хөрөнгийн зардал	-	21.1
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,980.7	1,980.7
Улсын төсвөөс санхүүжих	1,750.7	1,750.7
Орон нутгийн төсвөөс санхүүжих	230.0	230.0
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		200.6

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 46.2 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 43.2 сая төгрөгийн 4 алдааг залрууллаа.

Аудитаар 29.3 сая төгрөгийн үнэ бүхий барилгын их засварыг өмнөх үеийн үр дүн рүү хаасан, Хандиваар ирсэн 1.5 сая төгрөгийн үнэ бүхий номыг дутуу орлогод авсан, 0.4 сая бараа материалын үнэгүй орлого зөрүүтэй, багш ажилчдын шинжилгээ, сургалтын төлбөр, дата багцын төлбөр болох 11.7 сая төгрөг шилжүүлэхдээ шууд зардалд бүртгэснийг залрууллаа.

Аудитаар нийт 14.4 сая төгрөгийн зөрчил² илрүүлж тус зөрчилд 1 заалт бүхий зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

3.2 Албан шаардлага

3.2.1 Илрүүлэлт: Тус сургуулийн интернэтийн төлбөрийг Боловсролын мэдээллийн технологийн төв УТҮГ-аас төлсөн байхад 2022 онд интернэтийн төлбөрт 3.0 сая төгрөг төлж төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Боловсролын мэдээллийн технологийн төв УТҮГ-тай гэрээ байгуулан интернэтийн үйлчилгээ үзүүлж байгаа аж ахуйн нэгжтэй холбогдон сургуулийн интернэтийн тоног төхөөрөмжийг хүлээн авч үйл ажиллагаандаа тус интернэтийг хэрэглэн төсвийн хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэн ажиллаж төсвөөс мөнгөн хөрөнгө давхардуулан гаргаж байгааг таслан зогсоох.

3.3 Зөвлөмж

3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: 2022 оны 8 сард Бат арвай трейд ХХК-иас 11.4 сая төгрөгийн компьютерыг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 “Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно” гэсэн заалттай нийцээгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад газраас худалдан авдаг байдлыг зогсоож хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

төгрөгөөр

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Барилгын их засварын мөнгөн дүнг үр дүнрүү хаасан	1	29,607.4			1	29,607.4	1.0	29,607.4				
Ханидавын номын орлого дутуу тусгасан	1	1,527.9			1	1,527.9	1.0	1,527.9				
Бараа материалын үнэгүй орлого зөрүүтэй тайлагнагдсан	1	380.2			1	380.2	1.0	380.2				
Багш ажилчдын шинэжилгээ, дата багц, сургалтын төлбөрийг төлөхдөө тооцооны дансаар дамжуулал	1	11,671.0			1	11,671.0	1.0	11,671.0				
Дүн	4	43,186.5			4	43,186.5		43,186.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Зөрчил илрээгүй	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Дүн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Алдаа илэрээгүй								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Интернетийн төлбөр давхардуулан төлсөн	1	3,000.0			1	3,000.0		
Төрийн хэмнэлтийн хууль	1	11,400.0			1	11,400.0		
Дүн	2	14,400.0			2	14,400.0		
Нийт дүн	2	14,400.0			2	14,400.0		